

**МОНГОЛ ГАНЖУУРЫГ АРИУТГАН ЗАССАН ТУХАЙ АСУУДАЛД  
“Үлгэрийн далай” судрын жишээгээр**

**Д. Бүрнээ \***

Монгол Ганжуурын судлал тодруулбал төвд Ганжуурыг монгол хэлнээ хэрхэн орчуулсан, хэрхэн хянан тохиолдуулсан асуудал монгол орчуулгын судлалд ихээхэн сонирхолтой. Монгол Ганжуур дахь зохиолуудыг бүр 13-14 зуунаас орчуулж, хэвлэн нийтэлж олон түмэнд хүргэж байсан түүхтэй. Тухайлбал, монгол Ганжуурын доторхи “Алтангэрэл”, “Ихэд тонилгогч”, “Очроор огтлогч”, “Үлгэрийн далай” зэрэг хөлгөн судруудыг эрт цагаас орчуулан, хэвлэн нийтэлж байсан учир гар бичмэл болон бар хэвлэлээр өргөн тархсан ажээ. Монгол Ганжуур, Данжуурыг хэвлэн нийтлэхийн өмнө хуучин орчуулгуудыг хянан зассан тухай судлаачид тэмдэглэсэн байх боловч хэрхэн яаж хянан тохиолдуулсан талаар тусгайлан бичсэн судалгаа цөөн юм. Энэхүү өгүүлэлд монгол Ганжуурын 90 дүгээр ботид бүхий “Үлгэрийн далай” судрын жишээн дээр монгол Ганжуурыг ариутган зассан асуудлыг хөндөхийг зорьсон болно.

Түлхүүр үг

*Монгол Ганжуур, Төвд Ганжуур, төвд эх, орчуулга, ариутган засах, хувилбар эх*

Санскритаар "Даммамука", төвд хэлээр "Занлүн" (тө: mdzangs blun, мо: цэцэн тэнэг) хэмээх судрын монгол орчуулга болох "Үлгэрийн далай" судрыг Хөх хотын алдарт дуун хөрвүүлэгч Ширээт гүүш цорж монголчилсон билээ. "Занлүн" судрыг Ширээт гүүшээс гадна Зүүн авгын Цүлтэмлодой, Тойн гүүш, Зая бандид Намхайжамц нар орчуулсан боловч Ширээт гүүшийн орчуулга монголчуудын дунд өргөн дэлгэрч монголын ард түмний шүтээн төдийгүй хүртээмж болсоноороо онцлог юм. ОХУ-ын Санкт-Петербург хотын Дорно дахины гар бичмэл номын хүрээлэнгийн номын санд хадгалагдаж буй "Үлгэрийн далай" судрын төгсгөлд тус судрыг Ширээт гүүш орчуулсаныг тодорхой заан тэмдэглэсэн байх боловч бусад гар бичмэл, 1714 ба 1728 оны хэвлэл, монгол дармал Ганжуурын 90 ботид бүхий "Үлгэрийн далай" судрын төгсгөлийн үгд орчуулагчийн талаархи ямарваа мэдээлэл байхгүй. "Чакраварди Алтан хааны тууж" хэмээх монгол сурвалж бичигт өгүүлсэнээр 1602-1607 оны хооронд төвд Ганжуурыг Ширээт гүүш болон Манзушири Аюуш Ананд нар тэргүүлэн монгол хэлнээ орчуулсан гэсэн мэдээнээс Ширээт гүүш төвд Ганжуурын орчуулгад гол үүрэг гүйцэтгэснийг олж мэдэж байгаа билээ. Дундад зууны төвд, монгол сурвалж бичгүүдэд

\* МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Эх бичиг судлалын тэнхим

Ширээт гүүш цорж Ганжуурын Юмын аймгийн бүх судрыг орчуулсаныг тэмдэглэсэн байх боловч дармал Ганжуурын Юмын аймгийн судрын төгсгөлийн үгд Ширээт гүүш орчуулсан гэсэн мэдээ хоёрхон удаа тааралдаж байгаа бөгөөд "Зуун мянгат" судрын эхний ботийн төгсгөлийн үгд тус судрыг Ширээт гүүш орчуулсаныг дурдахын сацуу бас хянан зассан тухай тэмдэглэл ч байгаа юм. Харин Элдэв судрын аймагт бүхий "Үлгэрийн далай"-н төгсгөлийн үгд ариутган зассан гэсэн ямарваа мэдээ байхгүй.

Ширээт гүүшийн "Үлгэрийн далай"-н орчуулга бусад орчуулгаас өвөрмөц ялгаатай. Эн тэргүүн бүтцийн талаар ялгаатай бөгөөд энэ ялгаа монгол орчуулагчдын барьж орчуулсан төвд эх ялгаатай байсантай холбоотой. Тухайлбал төвд "Занлүн" судар 52 бөлөгтэй байхад төвд Ганжуураар уламжилж ирсэн эхүүд бүгд 51 бөлөгтэй, тэргүүн бөлгийн доторхи цадигийн тоогоор ч зөрөөтэй. "Үлгэрийн далай" сударт байх боловч төвд Ганжуурт байхгүй цадиг бол "Хан хөвгүүн Сусад"-гийн цадиг болно. Энэ бөлгийг монгол хэлнээс төвд хэлнээ орчуулж монголын Гунгаачойлин хийдэд барлахад төгсгөлийн 52 дугаар бөлөгт оруулж хэвлэжээ.

"Үлгэрийн далай" судрыг Ширээт гүүш 17 зууны эхээр орчуулсан байх бөгөөд тус орчуулгыг монгол Ганжуурыг 1718-1720 онд хэвлэхэд Бээжин барын төвд Ганжуурыг баримталж хянан зассан байна. Үүний нэг тод жишээг дараах хүснэгтэд бүхий өгүүлбэрээс харж болно.

Бээжин бараас бусад барын төвд Ганжуур	Бээжин барын төвд Ганжуур	Монгол дармал Ганжуур
Rgyal po de shin tu snying rje dang ldan pas mi la sogs pa skye bo <u>mang po bde skyid cing 'byor ba dang bde ba dang lo legs par ldan te rgyal po de skye bo mang po'i pha ma lta bur gyur to</u>	Rgyal po de shin tu snying rje dang ldan pas mi la sogs pa skye bo mang po'i pha ma lta bur gyur to	Тэр хаан нь маш их нигүүлсэгчийн тул хүмүүн тэргүүтэн олон иргэн нүүгүүдийн эцэг эх боллоо.

Дээрхи хүснэгтээс харвал монгол Ганжуур дахь эх Бээжин барын төвд судартай утга дүйж байгаа бөгөөд хүснэгтийн эхний баганад бүхий өгүүлбэрийн доогуур нь зурсан хэсэг буюу “олон амар жаргаж олз учрал ба амар амгалан хийгээд сайн жил төгсөж хаан ба ард олон” гэсэн хэсэг монгол орчуулгад байхгүй.

Бээжин бар дахь “Занлүн” судар бол Ширээт гүүшийн орчуулгын төвд эхээс ялгаатайг дээр дурдсан билээ. Тиймээс монгол Ганжуурыг ариутган шүүгчид Ширээт гүүшийн орчуулга Бээжин барын төвд эхээс зөрөөтэй болохыг анхаарч төвд эхэд ойртуулан буулгахыг чармайжээ. Тухайлбал Ширээт гүүшийн орчуулгад байхгүй үг өгүүлбэрийг нэмсэн байна. Жишээ нь “Үлгэрийн далай” судрын 1714 оны барын эхэд байхгүй үг өгүүлбэр нэмжээ. Үүнийг дараах хүснэгтээс харна уу.

Бээжин барын төвд Ганжуур	1714 оны барын монгол судар	Монгол дармал Ганжуур	1728 оны барын монгол судар
Bya gag gis nor bu med [med] par dge slong gis mthong yang tshul khirms	-----	Taqiy-a sibayun čindamani -yi jalıyiqui dur ayay-a tekimlig üjebesü ber	-----

bsrung ba'I phyir sdug bsngal myong bar byed kyi gtam mi zer ro		šayšabad saqiqu-yin tula jobalang-i üjebesü ber üges-I ese ügülebei	
--	--	--	--

Дээрхи хүснэгтээс харвал барын төвд сударт бүхий өгүүлбэр 1714 ба 1728 оны барын эхүүдэд байхгүй, харин монгол дармал Ганжуур дахь “Үлгэрийн далай” сударт нэмэн оруулсаныг харж болно. Мөн үг өгүүлбэрийг Бээжин барын судрыг баримталж хэрхэн зассаныг дараах хүснэгтээс харж болно.

Бээжин барын төвд Ганжуур	1714 оны барын монгол судар	Монгол дармал Ганжуур	1728 оны барын монгол судар
Bdag chos tshol ba 'di yang sangs rgyas su <u>bsgrub pa'i</u> phyir te	Minü nom erigsen ene ber burqan-u qutuy-i <u>olayulqu yin</u> tulada buyu	Minü nom erigsen ene ber burqan-u qutuy-I <u>bütügekü-</u> <u>yin</u> tulada buyu	Minü nom erigsen ene ber burqan-u qutuy-I <u>olayulqu yin</u> tulada buyu
dong de yang Me me tog gi <u>rdzing bur</u> gyur te	Tere γau ber čečeglig tü <u>qarsi</u> bolbai	Tere γau ber čečeglig-ün <u>čógerem</u> bolbai	Tere γau ber čečeglig tü <u>qarsi</u> bolbai
Sdig pa grogs po la bsten na ni <u>sdig pa'i</u> <u>chos skye bar 'gyur</u> <u>te</u>	Nigül tü nöküd-tür sitübesü <u>nigül ber</u> <u>nemeyü</u>	Nigül tü nökür-i sitübesü <u>kilinče tü</u> <u>nom törüjü</u>	Nigül tü nöküd-tür sitübesü <u>nigül ber</u> <u>nemeyü</u>

Дээрхи хүснэгтээс харвал монгол Ганжуур дахь эхийг илэрхий үг утгын хувьд өөрчилсөн болох нь харагдана. Үүнд 1714 болон 1728 оны барын сударт “олгуулахын тулд” гэснийг монгол Ганжуурын эхэд “бүтээхийн тулд”, “цэцэглэгт харш” гэснийг “цэцэглэгт цөөрөм”, “нүгэл бээр нэмыюу” гэснийг “хилинцэт ном төрж” гэж Бээжин барын төвд судрыг баримталж зассан болох нь харагдана. Зарим нэр томъёо, оноосон нэрийн орчуулгыг хэрхэн зассаныг дараах хүснэгтээс авч үзье.

Бээжин барын төвд Ганжуур	1714 оны барын монгол судар	Монгол дармал Ганжуур	1728 оны барын монгол судар
<u>Dge tshul gyis tshul</u> <u>khirms bsrungs pa</u>	<u>Yosutu buyantu toyin</u> <u>šayšabad saqiysan</u>	<u>Dgečül</u> kümün <u>šayšabad saqiysan</u>	<u>Yosutu buyantu toyin</u> <u>šayšabad saqiysan</u>
<u>Dge slong ma</u> ud pa la	Udpali neretü <u>simnanča</u>	Udpali neretü <u>ayay-a</u> <u>tekimlig</u>	Udpali neretü <u>simnanča</u>
Bya <u>bang</u> lta bu'i skad	<u>Qatan-u qariy-a</u> metü dayun	<u>Bang</u> sibayun-u dayun metü	<u>Qatun qariy-a</u> yin metü dayun
Ba glang mo	Ünegen <u>jayan</u>	Ünigen---	Ünegen <u>jayan</u>
Mgon med zas sbyin	Itegel ügei idegen <u>ögligetü</u>	Itegel <u>ügegün-e</u> idegen <u>ögligetü</u>	Itegel ügei idegen <u>ögligetü</u>

Дээрхи хүснэгтээс харвал “гэцэл” гэсэн үгийг 1714 ба 1728 оны эхэд “ёст буянт тойн”, харин монгол Ганжуурын эхэд “гэцэл” гэж төвдөөр нь зээлж авсан байна. Түүнчлэн 1714 ба 1728 оны эхэд “хатан хараа” гэсэн шувууны нэрийг монгол Ганжуурын эхэд “ван шувуу” гэж төвд үгийг хуулбарлан буулгажээ. “Гэлэнма” гэсэн үгийг 1714 ба 1728 оны эхэд “шамнанц” гэж санскритаар сэргээн орчуулсан, харин монгол Ганжуурын эхэд “аяга тэхимлиг” гэсэн уйгар гаралтай нэрээр буулгажээ. Зааны хүйсийг зааж “үнээ заан” гэж Ширээт гүүшийн орчуулсаныг монгол Ганжуурын эхэд “заан” гэсэн үгийг хасчээ. Түүнчлэн “Үлгэрийн далай” сударт олонтоо тааралдах гэрийн эзний нэрийг 1714 ба 1728 оны эхэд Итгэл үгүй идээн өглөгт гэснийг монгол Ганжуурын эхэд Итгэл үгээгүүнээ идээн өглөгт гэж зассан байна. Ингэж зассан нь гэрийн эзний өглөгч өгөөмөр зан төрхийг тодотгож өгснөөр ач холбогдолтой байна.

Ийнхүү хэлний зүй, үгсийн сан, найруулгын зарим засвар хийхдээ ерөнхий бүтцийг өөрчилсөнгүй. Өөрөөр хэлбэл бөлгийн дэс дараа, бөлгийн тоог яг хэвээр нь авчээ. Харин бусад төвд эхэд байхгүй "Хан хөвгүүн Сосади"-гийн бөлгийн тухайд барьж засах төвд эх байхгүй учир засварт хамгийн бага өртсөн гэж хэлж болно. Ширээт гүүшийн орчуулгыг ийнхүү засаж өөрчилсөн учир тус засварыг "Үлгэрийн далай" судрын нэг хувилбар гэж үзэж болох уу гэдэг асуулт бидэнд тулгарч байна. Нөгөөтэйгүүр Ширээт гүүшийн орчуулгын төвд эх бидэнд уламжилж ирсэн бусад төвд эхээс бүтэц, агуулгын талаар зөрөөтэй байгаа нь бидний анхаарлыг татаж байна. Энэ нь "Занлүн" судрын хэд хэдэн эх байсныг харуулах баримт болох юм. Монгол орчуулгын судлалд төвд эхийн судалгаа зайлшгүй холбогдож байгаа учраас төвд, монгол эхийг харилцаа холбоонд нь судлах явдал үр дүнтэй болохыг "Занлүн" судрын монгол орчуулгуудын судалгаа, Ширээт гүүшийн "Үлгэрийн далай" судрын орчуулгад хийсэн засвар бэлхнээ харуулж байна.

## ABSTRACT

The *Üliger-ün dalai* is a Mongolian version of the sutra known in Sanskrit as *Damamūko-nāma-sūtra* and in Tibetan as *Mdzangs blun zhes bya ba'i mdo* (Sutra of the Wise Man and the Fool), translated by Širegetü gūsi čorji. There are several other known Mongolian translations of this particular sutra, including those produced by Čülmilodoi, Toyin gūsi, and Zaya Pandita Namqayijamču. This translation of Širegetü gūsi čorji is renowned as the *Üliger-ün dalai* /Ocean of Tales/ and copies are widespread amongst Mongolians. It is recorded that *Üliger-ün dalai* was translated by Širegetü gūsi čorji at the end of the text which is preserved at the Institute of Oriental Manuscripts of St. Petersburg in Russia. There is no information about the translator at the colophons of other manuscripts, also in printed texts of 1714 and 1728 or the one that is included in the 90th Volume of Mongolian Printed Kanjur. According to Mongolian source named *Čakravarti Altan Qayan-u tuyuji*, translators under the leadership of Širegetü gūsi čorji and Manjusiri Ayuši Ananda translated the Tibetan Kanjur into Mongolian in 1602-1607. Thus, it is evident that Širegetü gūsi čorji played an important role in the Kanjur translation. According to some Tibetan and Mongolian source materials, Širegetü gūsi čorji translated all sutras from the division of the 'bum of Tibetan Kanjur. Nevertheless, there are only two indications of his name as a translator at the colophons of 'bum sutras. Širegetü gūsi čorji is identified as the translator of the *Biligün činadu kūrügen jaγun mingγan toyatu sutra*, but there is no indication about the edition.

*Mdzangs blun's* translation of Širegetü gūsi čorji is unique and different from other versions of translations. For instance, there are structural differences because Mongolian translators worked from different Tibetan versions of the same sutra. Thus the *Mdzangs blun* printed in Mongolia has 52 chapters while it has 51 chapters in all versions contained in the Tibetan Kanjurs. These versions even differ in the number of tales contained in the first chapters. The *Tale of Susadi Prince* is in the *Ūliger-ūn dalai* while it is not in Tibetan Kanjur, for example. This chapter appears to have been translated back into Tibetan and added as a 52nd chapter when printed at the monastery Gungachoiling in Mongolia.

Širegetü gūsi čorji translated *Ūliger-ūn dalai* at the beginning of the 17th century, and the translated text was edited and included in Mongolian Kanjur almost 100 years later. Today we still are not aware of any Tibetan text that exactly matches Širegetü gūsi čorji's Mongolian translation in terms of structure, style and content. Editors of Mongolian Kanjur have noted the differences between his translation and Tibetan texts, and hence, they have edited its vocabulary and content in accordance with Tibetan version, while retaining its general structure. In other words, they maintained the order and number of chapters as they were in the translation. The *Tale of Susadi Prince* is hardly edited since there is no existing Tibetan text to use in comparison. A question that arises in this connection that whether we can regard the most recently edited translation of Širegetü gūsi čorji as a version of *Ūliger-ūn dalai* sutra or not.

There are noticeable differences of structure and content between a Tibetan text that was used by *Ūliger-ūn dalai* for his translation and other Tibetan texts that are available to us today. This shows that there were several different versions of the Tibetan *Mdzangs blun* text. Studies on Mongolian translations of *Mdzangs blun* as well as later edition of Širegetü gūsi čorji's translation suggest to us that it would be fruitful to undertake a comparative study of both Mongolian and Tibetan texts since studies of the Tibetan text are related to our research on Mongolian translation.